



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 02-өдөр

Дугаар 5/01

Хэрлэн сум

Эрх бүхий албан
тушаалтан томилох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Авлигын эсрэг хуулийн 6 дүгээр зүйлийн 6.1.8, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.5 дахь заалт, Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам”-ын 3.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий аймгийн санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч, дотоод аудитор Г.Мөнхболд нь эрүүл мэндийн шалтгаанаар ажлаасаа чөлөөлөгдсөн тул тус албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч, дотоод аудитор Д.Пүрэвжавыг 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хяналт тавих, тайлагнах эрх бүхий албан тушаалтнаар томилсугай.

2.Д.Пүрэвжавт ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл урамшууллыг үндсэн цалингийн 20 хувьтэй тэнцэх хэмжээний нэмэгдлийг бодож олгохыг Нягтлан бодогч (Б.Оюунтуяа)-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулгад)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ